

# БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДААС ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЗААВАР

## Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү зааврын зорилго нь бүртгэлтэй компаниудаас хууль тогтоомж, Монголын Хөрөнгийн Бирж / цаашид МХБ гэх / ХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг ил тод болгох, компаниудаас ирүүлэх мэдээллийн төрөл, жагсаалтыг тогтоох, түүнийг компаниудаас цахим хэлбэрээр илгээх, хүлээн авах, хянах, боловсруулах, хадгалах, олон нийтэд мэдээллийг хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
2. Бүртгэлтэй компанийн эрх бүхий этгээдээс томилсон үнэт цаас хариуцсан ажилтан / цаашид үнэт цаас хариуцсан ажилтан гэх / нь мэдээллийг энэхүү зааврын хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв бөглөж цахим хэлбэрээр / интернэтийн холболтгүй тохиолдолд бичгэн хэлбэрээр / монгол /боломжтой тохиолдолд Англи/ хэл дээр ирүүлнэ.
3. Мэдээллийн сангийн бүрдэлтийг хангах зорилгоор компаниудаас интернэт холболтгүйн улмаас бичгэн хэлбэрээр ирүүлсэн мэдээлэл, материалыг Бүртгэлийн албаны компани хариуцсан мэрэгжилтэн /цаашид компани хариуцсан мэрэгжилтэн гэх/ мэдээллийн санд файл хэлбэрээр оруулж, хадгална.
4. Бүртгэлтэй компаниас цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг хянах, хавтаст материалд хадгалах, бүртгэл хөтлөх, боловсруулах, түүнийг нийтийн хүртээл болгох ажлыг компани хариуцсан мэрэгжилтэн, харин мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах болон түгээх үйл ажиллагааны аюулгүй, найдвартай байдлыг Мэдээлэл технологийн алба /цаашид МТА гэх / хариуцна.
5. Мэдээллийг зааварт заасан хугацаанд ирүүлэхтэй холбоотой ХК-иудын үүргийн хэрэгжилтийг Хяналтын алба /цаашид ХА гэх / хянаж, хариуцлага тооцно.

## Хоёр. Мэдээллийн маягтын ангилал, төрөл

6. Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр ирүүлэх мэдээллийн маягтыг дараах үндсэн 2 ангилалд хуваана. Үүнд:

*I. Компани болон компанийн үнэт цаасны талаархи мэдээний маягт*

*II. Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдээний маягт*

7. Компани болон компанийн үнэт цаасны талаархи мэдээний маягтууд нь дараах төрөлтэй байна. Үүнд:

*I-1 Компанийн ерөнхий мэдээлэл*

*I-2 Санхүүгийн тайлангийн мэдээлэл*

*I-3 Олон нийтэд санал болгосон үнэт цаасны талаархи мэдээлэл*

*I-4 ТУЗ болон ХШЗ-ийн талаархи мэдээлэл*

*I-5 Компанийн удирдлагын талаархи мэдээлэл*

*I-6 Компанийн гаргасан нийт хувьцааны 5 хувиас дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл*

*I-7 Их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэл*

*I-8 Бусдад барьцаа, баталгаа гаргасан тухай мэдээлэл*

*I-9 Томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын тухай мэдээлэл*

*I-10 Компанийн үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл*

8. Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдээний маягтууд нь дараах төрөлтэй байна. Үүнд:

*II-1 Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл*

*II-2 Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр*

**Гурав Маягтад мэдээлэл оруулах, түүнийг хүлээн авах, хянах  
болон олон нийтэд хүргэх**

9. Мэдээллийг холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан хугацаанд компаниас шаардан авч, мэдээллийн санд бүртгэх, түүнийг хянах, олон нийтэд хүргэх ажлыг компани хариуцсан ажилтан хариуцна
10. Энэхүү зааврын хавсралтанд заасан маягтанд холбогдох мэдээллийг тухайн компанийн үнэт цаас хариуцсан ажилтан болон албаны компани хариуцсан мэрэгжилтэн оруулна.
11. Компанийн үнэт цаас хариуцсан ажилтан, албаны компани хариуцсан мэрэгжилтэн нар нь тус тусын нууц кодтой байх бөгөөд мэдээллийн санд өөрсдийн кодоор хандаж мэдээлэл оруулна.
12. Мэдээллийг хавсралтад заасан маягтуудад бичгэн болон тоон хэлбэрээр оруулах бөгөөд ижил төрлийн олон мэдээлэл оруулах шаардлагатай газруудад “Нэмэх” гэсэн сонголтон дээр “enter” товчийг дарахад мэдээний талбар нэмэгдэнэ.
13. Маягтын “Хавсралт” гэсэн сонголттой хэсгүүдэд шаардлагатай материалыг эх хувиар нь хавсарган ирүүлнэ.
14. Эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулах шаардлагагүй материалыг “DOC” өргөтгөлтэй Word-ын файлаар ирүүлж болно.
15. Харин эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлэх шаардлагатай тогтоол, тушаал, шийдвэр бусад материалын хуулбарыг scanner-аар хуулбарлан “PDF” өргөтгөлтэй файл хэлбэрээр маягтын холбогдох хэсэгт хавсарган ирүүлнэ.
16. Хавсаргасан материалын хуулбар дахь үг үсэг, тамга тэмдэг болон түүнд тусгагдсан мэдээллүүд бүрэн гүйцэд харагдахаар тод гаргацтай байдлаар хуулбарлагдсан байна.
17. Маягтуудын “Бусад ” гэсэн сонголттой хэсгүүдэд тухайн асуудалтай холбоотой олон нийтэд хүргэх шаардлагатай бусад мэдээллийг оруулж болно.
18. МХБ-ийн мэдээллийн бааз дахь компанитай холбоотой зарим мэдээлэл нь маягтын холбогдох хэсэгт автоматаар бөглөгдөх боломжтой байна.
19. II-2 маягт дахь санхүүгийн тайлан балансын холбогдох үзүүлэлтүүдийг холбогдох ажилтан, мэрэгжилтэн оруулах бөгөөд үүний үндсэн дээр санхүүгийн харьцаанууд автоматаар тооцогдоно.
20. Үнэт цаас хариуцсан ажилтан нь мэдээний маягтыг бөглөж, “Хадгалагдах” сонголтыг дарахад компани хариуцсан мэрэгжилтэнд цахим шуудангаар мэдээлэл ирсэн тухай мэдэгдэл ирнэ.
21. Компани хариуцсан мэрэгжилтэн мэдэгдэл хүлээн авсны дараа ирсэн мэдээллийг агуулгын хувьд хянаж, шаардлага хангасан гэж үзвэл “Нийтлэх” гэсэн сонголтыг дарахад уг мэдээлэл нь олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдэж, МХБ-ийн web хуудсаар автоматаар үнэ төлбөргүй мэдээлэгдэнэ.
22. Хэрэв компани хариуцсан мэрэгжилтэн нь компаниас ирүүлсэн мэдээлэл, хавсралтаар ирүүлсэн материалыг хянаж, алдаатай буюу мэдээлэл дутуу орсон, түүнийг магадлах

шаардлагатай гэж үзвэл тухайн мэдээллийг ирүүлсэн үнэт цаас хариуцсан ажилтанд мэдэгдэж засварыг хийлгэнэ.

23. Үнэт цаас хариуцсан ажилтан нь мэдэгдлийн дагуу өөрийн оруулсан мэдээллийг хянаж өөрчлөлт оруулах шаардлагатай бол “Засвар” гэсэн сонголтоор холбогдох хэсгийн мэдээллийг шинэчилж, “Хадгалах” сонголтыг дарна.
24. Олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдсэн мэдээллийг зөвхөн компани хариуцсан мэрэгжилтэн засварлах, өөрчлөх, шинэчлэх эрхтэй байна.
25. Харин олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдсэн мэдээлэл нь компаниас тухайн маягтын дагуу шинэ мэдээлэл ирэх бүрд мэдээллийн баазад архивлагдаж хадгалагдана.
26. Мэдээллийн сан дахь компаниудын мэдээллийг тухайн компанийн болон мэдээллийн маягтын нэрээр эсвэл он сараар хайх, үзэх боломжтой байдлаар хадгална.

### **Дөрөв. Мэдээллийн санд мэдээлэл байршуулах болон олон нийтэд хүргэх хугацаа**

27. Энэхүү зааврын хавсралтад заасан мэдээллийг дараах хугацаанд компанийн үнэт цаас хариуцсан ажилтан МХБ-ийн мэдээллийн санд байршуулж олон нийтэд мэдээлнэ.
  - 27.1 Маягт I-1, I-3, I-4, I-5, I-6, I-7, I-8, I-9, I-10 оруулах мэдээллийг холбогдох шийдвэр, тогтоол гарснаас хойш 14 хоногийн дотор
  - 27.2 Маягт I-2 дахь санхүүгийн тайлангийн мэдээлэлд улирлын тайланг дараа сарын 20-ны дотор, жилийн тайланг дараа жилийн 04-р сарын 01-ний дотор
  - 27.3 Маягт II-1 дахь хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл болон холбогдох мэдээллийг олон нийтэд зарлахаас 7 хоногийн өмнө
  - 27.4 Маягт II-2 дахь хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлаас гарсан шийдвэр, тогтоол холбогдох мэдээллийг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор
28. Мэдээллийг компани хариуцсан мэрэгжилтэн хянаж ажлын 1 хоногт багтаан олон нийтэд мэдээлнэ.

### **Тав. Мэдээллийн сангийн нууцлал**

29. Компаниас мэдээлэл ирүүлэх, шинэчлэх, засвар, өөрчлөлт оруулах, олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэх тухай бүр холбогдох ажилтан, мэрэгжилтний тус тусын нууц кодоор бүртгэл хөтлөгдөж, мэдээллийн санд хадгална.
30. Мэдээллийн баазад хандаж мэдээлэл оруулах эрх бүхий ажилтан, мэрэгжилтэнд нууц кодыг тусгай зориулалтын дугтуйнд хийж хүлээлгэн өгөх бөгөөд түүнийг олгох, өөрчлөх, бүртгэл хөтлөх ажлыг МТА хариуцна.
31. Компанитай холбоотой мэдээлэл нь мэдээллийн санд хадгалагдах бөгөөд түүнийг албан хэрэгцээнд зориулан хэрэглэх, боловсруулалт хийх боломжтой байна.
32. Албаны мэрэгжилтнүүд нь мэдээллийн баазад цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг хууль, тогтоомжийн хүрээнд нийтийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийн зах зээл дэх мэдээллийн ил

тод, үр дүнтэй байдлыг хангах, компанийн сайн засаглалыг бүрдүүлэх, судалгаа хийх зорилгоор ашиглаж болно.

### **Зургаа. Хариуцлага**

33. Нууц кодны нууцлалыг тухайн код эзэмшигч болон МТА хариуцна.
34. Мэдээллийн сан дахь мэдээллийн бүрэн бүтэн, найдвартай байдлыг МТА хариуцна.
35. МХБ ХК-д цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл ирүүлсэн этгээд, олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдсэн мэдээллийн үнэн зөвийг компани хариуцсан мэрэгжилтэн тус тус хариуцна.
36. Энэхүү зааврын дагуу ирүүлэх мэдээллийг хууль тогтоомж, гэрээнд заасан хугацаанд зохих маягтын дагуу үнэн зөв бүрэн ирүүлээгүй, компаниас ирүүлсэн мэдээллийг олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэхээс өмнө агуулгын хувьд хянаагүйгээс үүссэн үр дагаврыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтан хариуцах бөгөөд хууль тогтоомж, “Үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээ”-ний дагуу хариуцлага хүлээлгэнэ.

2009.11.04-ны өдрийн МХБ ХК-ийн Гүйцэтгэх захирлын № 157 тоот тушаалаар 6 бүлэг, 38 заалт, 12 маягтын хавсралт бүхий зааврыг баталсан.

## I. КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Маягт № I-1 Компанийн ерөнхий мэдээлэл

1	Компанийн нэр				
2	Байршил хаяг				
3	Байгуулагдсан огноо		..... он		
4	МХБ –д бүртгүүлсэн огноо		..... он ..... сар ..... өдөр		
5	Код	Тоон	.....		
		Үсгэн	.....		
6	Хувьчлах шийдвэр гаргасан	Эрх бүхий этгээд			
		Дугаар	№ .....		
7	Улсын бүртгэлийн болон Регистрийн дугаар		Регистрийн дугаар : .....		
8	Хувьцааны тоо ширхэг	Төрөл	Энгийн	Төрийн мэдэлд	Давуу эрхийн
		Зарласан	..... ширхэг	..... ширхэг	..... ширхэг
		Гаргасан	..... ширхэг	..... ширхэг	..... ширхэг
9	Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ		Анхны үнэ: ..... /төг/		Одоогийн үнэ: ..... /төг/
10	Хувьцаат капиталын дүн		Анхны дүн: ..... /төг/		Одоогийн дүн: ..... /төг/
11	Компанийн дүрэм	\Сүүлчийн байдлаар\	Компанийн дүрмийн хуулбар		
		ХНХ шийдвэрийн огноо, дугаар	..... он ..... сар ..... өдөр		№.....
12	Үйл ажиллагааны чиглэл		1.		
			2.		
			3. <u>Нэмэгдэх</u>		
13	Эзэмшиж буй тусгай зөвшөөрөл лиценз:	Зөвшөөрлийн утга	Авсан огноо	Олгосон байгуулга	Хугацаа
		1.	..... он		
		2.	..... он		
		3. <u>Нэмэгдэх</u>	..... он		
14	Толгой, Охин, Хараат, компанийн тухай мэдээлэл	Толгой Компани	Нэр		
			Хаяг		
			Үйл ажиллагааны чиглэл		
		Охин Компани	Нэр		
			Хаяг		
			<u>Нэмэгдэх</u> Үйл ажиллагааны чиглэл		
		Хараат компани	Нэр		
			Хаяг		
			<u>Нэмэгдэх</u> Үйл ажиллагааны чиглэл		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

## I. КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Маягт № I-2 Санхүүгийн тайлангийн мэдээ

1	..... улирлын санхүүгийн тайлан		/төгрөгөөр/	
2	Санхүүгийн тайлан		Эхний үлдэгдэл ... он .....сар..... өдөр	Эцсийн үлдэгдэл ... он .....сар..... өдөр
3	Санхүүгийн үзүүлэлтүүд		Санхүүгийн тайлангийн хуулбар	
			<u>Хавсралт</u>	
	Нийт хөрөнгө			
	Өр төлбөрийн нийт дүн			
	Эзэмшигчдийн өмчийн дүн			
	Нийт хувьцааны тоо ширхэг		.....ширхэг	.....ширхэг
4	Орлого үр дүнгийн тайлангийн үзүүлэлт			
	Нийт борлуулалтын орлого			
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			
	Нийт ашиг			
	Цэвэр ашиг			
	Ногдол ашиг	Энгийн		
		Давуу эрхийн		
	Нэгж хувьцааны дансны үнэ		Эзэмшигчдийн өмч / хувьцааны тоо ширхэг	Эзэмшигчдийн өмч / хувьцааны тоо ширхэг
	Хувьцааны тухайн өдрийн хаалтын ханш		..... төг	..... төг
5	Санхүүгийн харьцаанууд	1. Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	Цэвэр ашиг /нийт хөрөнгө	Цэвэр ашиг /нийт хөрөнгө
		2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж (ROE)	Цэвэр ашиг / эзэмшигчдийн өмч	Цэвэр ашиг / эзэмшигчдийн өмч
		3. Нийт хөрөнгийн эргэц (ROTA)	Нийт орлого / нийт хөрөнгө	Нийт орлого / нийт хөрөнгө
		4. Нэгж хувьцааны өгөөж (EPS)	(Цэвэр ашиг – давуу эрхийн хувьцааны Ног.А) / гаргасан энгийн хувьцааны тоо	(Цэвэр ашиг – давуу эрхийн хувьцааны Ног.А) / гаргасан энгийн хувьцааны тоо
		5. Үнэ ашгийн харьцаа (P/E Ratio)	Хаалтын ханш / нэгж хувьцааны өгөөж	Хаалтын ханш / нэгж хувьцааны өгөөж
6	Аудит хийсэн байгууллагын нэр			
7	Аудитын дүгнэлт хийгдсэн огноо		..... он ..... сар ..... өдөр	
8	Аудиторын дүгнэлт		Дүгнэлтийн хуулбар	<u>хавсралт</u>

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

## I. КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Маягт № I-3 Олон нийтэд санал болгосон үнэт цаасны талаархи мэдээлэл

1.	Үнэт цаасыг бүртгэж зөвшөөрөл олгох тухай СЗХ –ны шийдвэр	Дугаар	№ .....
		Огноо	..... он ..... сар ..... өдөр
2	Үнэт цаасны төрөл	.....	
3	Олон нийтэд санал болгож буй үнэ	..... төгрөг	
4	Олон нийтэд санал болгож буй тоо ширхэг	..... ширхэг	
5	Олон нийтэд санал болгож буй хувьцааны хувь хэмжээ	..... %	
<b>* Шинээр олон нийтэд санал болгосон үнэт цаасны талаархи мэдээлэл /сонголт/</b>			
1	Шинээр гаргаж буй хувьцаа	Шийдвэр гаргасан этгээд	
		Шийдвэр №	
2	Шинээр гарч буй хувьцааны мэдээлэл	Тоо ширхэг	..... ширхэг
		Арилжигдсан үнэ	..... төгрөг
		Үнийн дүн	..... төгрөг
3	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Зарцуулалтын утга	Үнийн дүн
		1.	..... төгрөг
		2.	..... төгрөг
		3.	<i>Нэмэгдэх</i> ..... төгрөг
<b>* Нэмж гаргасан үнэт цаасны талаархи мэдээлэл</b>			
1	Нэмж гаргасан хувьцаа	Шийдвэр гаргасан этгээд	
		Шийдвэр №	
2	Нэмж гаргасан хувьцааны мэдээлэл	Тоо ширхэг	..... ширхэг
		Нэгжийн үнэ	..... төгрөг
		Үнийн дүн	..... төгрөг
3	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Зарцуулалтын утга	Үнийн дүн
		1.	..... төгрөг
		2.	..... төгрөг
		3.	<i>Нэмэгдэх</i> ..... төгрөг
<b>* Олон нийтэд санал болгож буй бондын талаархи мэдээлэл</b>			
1	Олон нийтэд санал болгож буй бонд	Шийдвэр гаргасан этгээд	
		Шийдвэр №	.....
2	Бондын мэдээлэл	Тоо ширхэг	..... ширхэг
		Нэгжийн үнэ	..... төгрөг
		Үнийн дүн	..... төгрөг
		Бондын жилийн хүү	..... %
		Бондын хугацаа	..... сар
3	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Зарцуулалтын утга	Үнийн дүн
		1.	..... төгрөг
		2.	..... төгрөг
		3.	<i>Нэмэгдэх</i> ..... төгрөг

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

## I.КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Маягт № I-4 ТУЗ болон ХШЗ-ийн талаархи мэдээлэл

Д/д	* ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл				
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшдэг бол хувь хэмжээ	Ажлын газар, Албан тушаал
1.				...%	
2.				...%	
3.				...%	
4.				...%	
5.				...%	
6.				...%	
7.				...%	
8.				...%	
9.	<u>Нэмэгдэх</u>			...%	
* ХШЗ-ийн гишүүдийн мэдээлэл					
1.				...%	
2.				...%	
3.				...%	

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

## I.КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Маягт № I-5 Компанийн удирдлагын талаархи мэдээлэл

Д/д	Албан тушаал	Овог	Нэр	Хувьцаа эзэмшдэг бол хувь хэмжээ	Регистрийн дугаар
1				...%	
2				...%	
3	<u>Нэмэгдэх</u>			...%	

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:



## I. КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Маягт № I-6 Компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувиас дээш хувийг  
эзэмшигчдийн мэдээлэл

д/д	*Хувьцаа эзэмшигчид		*Эзэмшиж буй хувьцаа		Ажлын газар, Албан тушаал
	Овог	Нэр	Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь	
1.			..... Ш	.... %	
2.			..... Ш	.... %	
3.			..... Ш	.... %	
4.			..... Ш	.... %	
5.			..... Ш	.... %	
6.			..... Ш	.... %	
7.			..... Ш	.... %	
8.	<u>Нэмэгдэх</u>		..... Ш	.... %	

Мэдээлэл оруулсан огноо:  
Шинэчлэгдсэн огноо:

## I. КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Маягт № I -7 Их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэл

1. Хэлцлийн утга				
2. Их хэмжээний хэлцлийг баталсан ХНХ	Шийдвэрийн дугаар	№.....	Гэрээний хуулбар <u>Хавсралт</u>	
	ХНХ –ын ирц	Нийт	Тоо : .....	Хувь: .....
		Зөвшөөрсөн	.....ширхэг	..... %
		Татгалзсан	.....ширхэг	..... %
		Түдгэлзсэн	.....ширхэг	..... %
	Огноо	..... он ..... сар ..... өдөр		
3. Хэлцэл	Үнийн дүн		..... төгрөг	
	Хийхээс өмнөх сүүлийн балансын нийт активийн дүн		..... төгрөг	
	Үнийн дүнгийн нийт активт эзлэх хувь		..... %	
4. Гэрээний нөгөө тал				
5. Нөхцөл болзол				
6. Хугацаа	Эхлэх	..... он ..... сар ..... өдөр		
	Дуусах	..... он ..... сар ..... өдөр		
7. Гэрээ хийгдсэн огноо		..... он ..... сар ..... өдөр		
8. Бусад				

Мэдээлэл оруулсан огноо:  
Шинэчлэгдсэн огноо:

**I.КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ**

Маягт №I -8 Бусдад барьцаа, баталгаа гаргасан тухай мэдээлэл

1.Зээлдэгч		
2.Зээлдүүлэгч		
3.Зээлийн дүн		..... төгрөг
4.Барьцаа хөрөнгө	Барьцаат хөрөнгийн гэрчилгээний дугаар	.....
	Нэр	
	Байршил	
	Үнийн дүн	..... төгрөг
	Компанийн өөрийн хөрөнгийн дүн	..... төгрөг
	Өөрийн хөрөнгөд барьцааны хөрөнгийн үнийн дүнгийн эзлэх хувь	.... %
	Барьцааны хугацаа	..... сар
5.Шийдвэр	Гаргасан этгээд	
	Огноо	..... он ..... сар ..... өдөр
6.Бусад		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

Хавсралт 9

**I.КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ**

Маягт №I -9 Томоохон зээлдүүлэгчид , харилцагчдын тухай мэдээлэл

1.	<b>Харилцагчийн нэр</b>	1. 2.		
	Хаяг	1. 2.		
	Том харилцагч гэж тооцсон үндэслэл	1. 2.		
	Ямар харилцаатай	1.Бэлтгэн нийлүүлэгч <input type="checkbox"/>		
		2.Худалдан авагч <input type="checkbox"/>		
		3.Томоохон зээлдүүлэгч <input type="checkbox"/>		
	Сүүлийн 3 жил	2006 он	2007 он	2008 он
2.	<b>Бэлтгэн нийлүүлэгчийн нэр</b>			
	Нийт худалдан авалтын дүнд эзлэх хувь	..... %	..... %	..... %
3.	<b>Худалдан авагчийн нэр</b>			
	Нийт борлуулалтын дүнд эзлэх хувь	..... %	..... %	..... %
4.	<b>Том зээлдүүлэгчийн нэр</b>			
	Нийт өрийн дүнд эзлэх хувь	..... %	..... %	..... %
5.	Бусад			

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

***I.КОМПАНИ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ***

**Маягт №I -10** *Компанийн үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл*

1.	Бусад мэдээ	
2.	Мэдээллийн огноо	

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

## II.ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭЭ

Маягт № II-1

Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдээгдэл

1.	Хувь нийлүүлэгчдийн хурал	Ээлжит <input type="checkbox"/>	Ээлжит бус <input type="checkbox"/>
2.	ХНХ хуралдах хугацаа	..... он ..... сар ..... өдөр ..... цаг	
3.	Бүртгэх өдөр	..... он ..... сар ..... өдөр	
4.	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах өдөр	..... он ..... сар ..... өдөр	
	Зарлуулсан эх сурвалж /он, сар, өдөр, дугаар/	1. .... /.....он, .....сар, ..... өдөр, ..... дугаар/ 2. .... /.....он, .....сар, ..... өдөр, ..... дугаар/ 3. .... /.....он, .....сар, ..... өдөр, ..... дугаар/	
5.	Хуралдах газрын хаяг		
6.	Хурлаар хэлэлцэх асуудлууд	1. 2. 3. 4.  <i>Нэмэгдэх</i>	
7.	Шийдвэр	Гаргасан этгээд	
		Огноо, дугаар	..... он ..... сар ..... өдөр №.....
8.	Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн		
9.	Холбоо барих утас		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

## II.ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭЭ

Маягт № II-2 Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр

<b>1.Хувь нийлүүлэгчдийн хурал</b>	Ээлжит <input type="checkbox"/>	Ээлжит бус <input type="checkbox"/>
Хуралдсан огноо	..... он ..... сар ..... өдөр ..... цаг	
Хуралдсан газар		
Хурлын ирц	..... %	
<b>2.ХНХ –ын шийдвэр</b>	<b>Санал</b>	<b>Хувь</b>
1.	Зөвшөөрсөн	....%
	Татгалзсан	....%
	Түдгэлзсэн	....%
<i>Хавсралт</i>		
2.	Зөвшөөрсөн	....%
	Татгалзсан	....%
	Түдгэлзсэн	....%
<i>Хавсралт</i>		
3.	Зөвшөөрсөн	....%
	Татгалзсан	....%
	Түдгэлзсэн	....%
<i>Хавсралт</i>		
4.	Зөвшөөрсөн	....%
	Татгалзсан	....%
	Түдгэлзсэн	....%
<i>Хавсралт Нэмэгдэх</i>		
<b>3.Хурлын протокол</b>	Хурлын протоколын хуулбарыг хавсаргана. <i>Хавсралт</i>	
<b>4.Бусад асуудал</b>		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо: